



Улсын гаалийн ерөнхий газрын даргын 2008 оны 756 дугаар
тушаалын хавсралт

БАРАА, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ГААЛИЙН ТЭМДЭГЛЭГЭЭ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг.Ерөнхий зүйл

1.1. Гаалийн хяналтанд байгаа бараа, тээврийн хэрэгсэл, тээврийн болон худалдааны бичиг баримтад өөрчлөлт орохгүй байх нөхцөлийг хангах үүднээс гаалийн хяналтын зорилгоор тэмдэглэгээ хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулах, хяналт тавихад энэ журмын зорилго оршино.

1.2. Гаалийн хяналтад байгаа бараа, тээврийн хэрэгсэл, тэдгээрийг дагалдах тээврийн болон худалдааны бичиг баримтад гаалийн байгууллагын албан тушаалтан гаалийн хяналтын зорилгоор тэмдэглэгээ хэрэглэж битүүмжлэх бөгөөд гаалийн тэмдэглэгээний бүрэн бүтэн байдлыг гаалийн харилцаанд оролцогч тал хариуцна.

Хоёр.Гаалийн тэмдэглэгээ хийх

2.1. Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, тэдгээрийг дагалдах тээврийн болон худалдааны бичиг баримтад гаалийн хяналтын зорилгоор тэмдэглэгээ хийхдээ тээврийн хэрэгслийн төрөл, барааны баглаа боодол зэргээс шалтгаалан гаалийн тэмдэглэгээний аргуудаас боломжтойг нь сонгож хэрэглэнэ.

2.2. Гаалийн тэмдэглэгээг онцлогоос нь шалтгаалан битүүмжлэл, тэмдэглэгээ гэж ангилна.

2.3. Битүүмжлэл нь дараахь хэлбэртэй байна:

- 2.3.1. нэг удаагийн гаалийн ломбо болон бэхэлгээ утас ашиглах;
- 2.3.2. олон удаагийн электрон ломбо хэрэглэх;
- 2.3.3. лац тавих;
- 2.3.4. сав, баглаа, боодол болгон боож, түүнд тэмдэглэгээ хийх;
- 2.3.5. бичиг баримтыг уут, сав, дугтуйнд хийж, түүнд тэмдэглэгээ хийх;
- 2.3.6. тэмдэглэгээ бүхий наалт хэрэглэх;
- 2.3.7. байршил тодорхойлогч системийг ашиглах гэх мэт.

2.4. Тэмдэглэгээг дараахь хэлбэрээр хийж болно:

- 2.4.1. тоон болон үсгэн тэмдэглэгээ тавих, кодлох;
- 2.4.2. жин, овор хэмжээ, тоо ширхэгийг тодорхойлж тэмдэглэх;
- 2.4.3. гадна, дотно шинж байдлыг тодорхойлон бичих;
- 2.4.4. схем, дүрс зургаар илэрхийлэх;
- 2.4.5. холбогдох тайлбар, тодруулга, лавлагааг гаргуулан авч баримтжуулах;
- 2.4.6. бичлэг хийж дүрс зургийг буулгах фото зургийг авах;
- 2.4.7. хуулбарлан авах;
- 2.4.8. хуудсыг дэс дараалуулан тоогоор дугаарлах;
- 2.4.9. үсэг, дугаар бүхий код ашиглах;
- 2.4.10. тамга, тэмдэг дарж баталгаажуулах гэх мэт.

2.5. Гаалийн хяналтад байгаа бараа, тээврийн хэрэгслийг хадгалж буй байр, агуулах, талбайд болон гаалийн хяналтад байгаа бараанаас авах дээж, сорьц, загварт гаалийн хяналтын зорилгоор тэмдэглэгээ хийхэд энэ журмын 2.3, 2.4-т заасан аргуудаас боломжтойг нь сонгож хэрэглэнэ.

2.6. Энэ журмын 2.3.7-д заасан системийг тээврийн хэрэгсэлд суурилуулсан тохиолдолд түүнийг тухайн тээврийн хэрэгсэлд бөх бат байрлуулсан эсэхийг шалгаж, гаалийн тэмдэглэгээг хэрэглэж битүүмжилнэ.

2.7. "Барааг хилийн чанадад түр хугацаагаар гаргах", "Барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах" горимд байршуулах тоног төхөөрөмж, техник хэрэгслийн техникийн үзүүлэлт, марк, артикул, зориулалт, жин, тоо, овор хэмжээ, шинж байдлыг тодорхойлон бичих, дүрс зургийг нь фото болон дижитал аппаратаар авч, компьютерт тусгай файл үүсгэж хадгалах бөгөөд тэдгээрийг гаалийн хилээр буцаан нэвтрүүлэхдээ зураг болон тодорхойлолтуудтай нэг бүрчлэн тулгасны эцэст бүрдүүлэлт хийнэ.

Гурав. Гаалийн лац, ломбо, бэхэлгээ утсанд тавигдах ерөнхий шаардлага

3.1. Лац, ломбо болон бэхэлгээ утас нь дараахь шаардлага хангасан байна:

3.1.1. бөх бат, эдэлгээтэй байх;

3.1.2. тухайн ломбыг тавихад аль болох богино хугацаа зарцуулахаар байх;

3.1.3. шууд шалгах болон онцлон таних боломжтой байх;

3.1.4. эвдэлгүй тайлах эсхүл ул мөр үлдээлгүй салгах, олон удаа хэрэглэх боломжгүй байх;

3.1.5. ломбоны нүх нь бэхэлгээ утсанд тохирсон, ломбыг хавчихад бэхэлгээ утасны урт нь хөдөлгөөнгүй, тэдгээрт илэрхий гэмтэл учруулалгүйгээр их бага хэмжээгээр онгойлгох боломжгүй байх;

3.1.6. олон удаа хэрэглэх ломбоноос бусдыг нэгээс дээш удаа хэрэглэх боломжгүй байх;

3.1.7. хуулбарлах буюу хуурамчаар үйлдэхэд төвөгтэй байхаар хийх;

3.1.8. осол аваар, цаг агаарын нөхцөл байдал, химийн урвал гэх мэт гадны хүчин зүйлээс шалтгаалан чанараа амархан алдах, ул мөргүй хөндөгдөх явдлаас урьдчилан сэргийлэх үүднээс лац, ломбоны бэхэлгээ утасны материал нь аль болох бөх бат байх;

3.1.9. лац, ломбо дээр "Монголын гааль" гэсэн үгийг монгол, англи хэлний аль нэгээр хэрэглэж, тэр нь гаалийн битүүмжлэл болохыг харуулах;

3.1.10. үсэг, дугаар бүхий код ашиглан тухайн тэмдэглэгээг тавьсан гаалийн байгууллагыг таних боломжийг бүрдүүлэх гэх мэт.

Дөрөв. Гаалийн тэмдэглэгээ өөрчлөгдсөн нөхцөлд авах арга хэмжээ

4.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас бараа, тээврийн хэрэгсэл устах, үрэгдэх, гэмтэж муудах аюул тулгарсан үед гаалийн харилцаанд оролцогч тухайн нөхцөл байдлыг хамгийн ойр орших гаалийн байгууллагад шуурхай мэдээлж, түүний зөвшөөрөлтэйгээр гаалийн тэмдэглэгээг авах, өөрчлөх эрхийг эдэлнэ.

4.2. Энэ журмын 4.1-д заасан нөхцөл байдлыг гаалийн байгууллагад мэдээлэх боломжгүй тохиолдолд төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны хяналтын дор гаалийн тэмдэглэгээг бусад этгээд авч, өөрчилж болно.

4.3. Энэ журмын 4.1, 4.2-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд холбогдох гаалийн тэмдэглэгээг авсан, өөрчилсөн этгээд нь энэхүү журмын хавсралтаар батлагдсан “Гаалийн тэмдэглэгээг өөрчилсөн тухай акт”-ын маягтыг нөхөн бичиж, бодит аюул учирсныг тухайн орон нутаг дахь цагдаагийн болон онцгой байдлын алба, засаг захиргааны нэгж, байгууллагын холбогдох бичиг баримтаар нотолно.

4.4. Мөн гаалийн тэмдэглэгээ энэ журмын 4.1-д зааснаас бусад шалтгааны улмаас өөрчлөгдсөн тохиолдолд битүүмжлэлийн бүрэн бүтэн байдлыг хангах үүрэг бүхий гаалийн харилцаанд оролцогч байгууллага, түүний албан тушаалтан гаалийн байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

4.5. Энэ журмын 4.3-т заасан тохиолдолд шаардлагатай гэж үзвэл гаалийн байгууллага гаалийн тэмдэглэгээний бүрэн бүтэн байдлыг хангах үүрэг бүхий гаалийн харилцаанд оролцогч байгууллага, түүний албан тушаалтныг байлцуулан тухайн бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн шалгалт хийж, холбогдох арга хэмжээг авна.

4.6. ”Барааг дамжуулан өнгөрүүлэх болон шилжүүлэн ачих” горимд байршуулах бараа, тээврийн хэрэгсэлд гадаадын болон дотоодын гаалийн байгууллагын тавьсан тэмдэглэгээг өөрчлөх тохиолдолд гаалийн тэмдэглэгээг шинээр тавьсан гаалийн байгууллага гаалийн тэмдэглэгээ өөрчилсөн тухай актыг маягтын дагуу үйлдэж, шаардлагатай гэж үзвэл тухайн бараа, тээврийн хэрэгсэлд шалгалт хийж, холбогдох арга хэмжээ авна.

Тав. Бусад

5.1. Энэ журмаар зохицуулагдаагүй асуудлыг гаалийн болон бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

5.2. Энэ журмыг зөрчсөн тохиолдолд гаалийн болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.



---oOo---

журмын хавсралт

ГААЛИЙН ТЭМДЭГЛЭГЭЭГ ӨӨРЧИЛСӨН ТУХАЙ АКТ

20....оны....сарын....өдөр

1.Бараа эзэмшигчийн нэр, регистрийн дугаар, хаяг, утас.
.....
.....
.....

2.Барааны нэр, төрөл, марк, артикул, жин, тоо, овор хэмжээ, үнийн дүн, чингэлгийн
дугаар.
.....
.....
.....

3.Бараа, тээврийн хэрэгсэлд байсан гаалийн тэмдэглэгээний арга, лац ломбоны дугаар,
огноо
.....
.....
.....

4.Гаалийн тэмдэглэгээнд өөрчлөлт орох болсон шалтгаан.
.....
.....
.....



.....

5.Шинээр тавьсан тэмдэглэгээний шинж байдал.

....

.....
.....
.....
.....

6.Гаалийн тэмдэглэгээг өөрчлөх шийдвэр гаргасан гаалийн байгууллага, албан тушаалтны овог, нэр, гарын үсэг, огноо

.....
.....

.....
.....
.....

7.Акт үйлдсэн этгээдийн овог, нэр, албан тушаал, хаяг, утас

.....
.....
.....
.....

АКТ ҮЙЛДСЭН

/...../